



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар

А/151

Мандалговь

“Авто замын хашлага, хүйтэн асфальт, битум”
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний
хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Замын сангийн хөрөнгөөр санхүүжих “Авто замын хашлага, хүйтэн асфальт, битум” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ж.Уянга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Т.Мөнхбаяр (Иргэний төлөөлөл)

Ж.Базарсад (Хот тохижуулах газрын инженер)

Нарийн бичиг:

Э.Энхжаргал ((Иргэний төлөөлөл)

М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Уянга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

10-1170050